



76

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 496

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрүүл чийрэг Монгол хүн” бүлгийн 177 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл” стратеги (2014 - 2019 он) – ийг хавсралтаар баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ) -д тус тус даалгасугай.

3. Стратегийн хэрэгжилтэнд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тооцон тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамааруулан шийдвэрлэж байхыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Санхүү эдийн засгийн хэлтэс (Д.Төмөрбаатар), Гадаад хамтын ажиллагааны хэлтэс (Д.Янжмаа) –т тус тус даалгасугай.

4. Стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, үр дүнг жил бүрийн 7 дугаар сарын 25, 1 дүгээр сарын 25-ны дотор Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлж байхыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ

003084



## “ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ” СТРАТЕГИ (2014-2019 ОН)

### Нэг. Өнөөгийн байдал

#### 1.1. Дэлхий дахинд эмнэлгийн яаралтай тусламжийн байдал

ДЭМБ-ын орчин үеийн гол үзэл баримтлал болох эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиг хандлагыг хэрэгжүүлэх, ялангуяа осол гэмтлийн үед эмнэлгийн яаралтай тусламжийг шуурхай хүргэхэд эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах чадавх, бэлэн байдал шийдвэрлэх үүрэгтэй. Дэлхийн анагаах ухаанд Яаралтай тусламжийн анагаах ухаан (Emergency Medicine) хурдацтай хөгжиж байна.

Дэлхийн хүн амын нас баралтын 2030 оны төлөв байдлаар зам тээврийн ослын нас баралт нь нийт нас баралтын шалтгааны дотор 5 дугаарт орж байна.

Мөн түүнчлэн хөгжиж байгаа улс орнуудад хотжилтын хурдацтай холбоотойгоор зүрхний шигдээс, тархины харвалт, хордлого, халдварт өвчин, цочмог эмгэгүүд, гэмтлийн хэлбэр, явц, тавиланд гарч байгаа өөрчлөлтөөс үзэхэд эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг хурдацтай, тогтвортой өргөжүүлэх шаардлага гарч байна.

#### 1.2. Монгол улс дахь яаралтай тусламжийн өнөөгийн байдал

Гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын улмаас нас барах тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 1990 онд хүн амын нас баралтын 5 дахь, 2000 оноос хойш 3 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна. Жилд дунджаар 3000 гаруй хүн буюу 5 хүний нэг нь гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгааны улмаас нас барж байна. Жилээс жилд зам тээврийн ослын шалтгаант нас баралт нэмэгдэж байгаа ба 10000 хүн амд 2010 онд 1.8, 2011 онд 1.9 байсан бол 2012 онд 2.1 болж нэмэгдсэн байна.<sup>1</sup>

Манай улсад осол гэмтэлд өртөгсдөд газар дээр нь үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээ хангалтгүй гол төлөв тээвэрлэх маягаар ажиллаж байгаагаас гадна эмнэлгүүд түргэн тусламжийн байгууллагатай холбогдох харилцаа холбоо байхгүй, эмнэлгийн эрчимт эмчилгээ, амь насыг аврах үйл ажиллагаанаас гадна яаралтай тусламжийн хүрээнд өвчтөнийг эрэмбэлэн ангилах, техник тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангах, бэлтгэгдсэн мэргэжлийн хүний нөөцөөр хангах зэрэг асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх боломж алга байна.

Түргэн тусламжийн үйлчилгээг үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтад оруулах, менежментийг сайжруулах, техник, багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртсон нэгдсэн

<sup>1</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2012, ЭМХТ

тогтолцоо бий болгох зорилгоор “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газрын 2010 оны 318 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Судалгаанаас үзэхэд 2012 оны байдлаар улсын хэмжээнд түргэн тусламжийн 684888 дуудлага хүлээж авсаны 43 хувь нь нийслэлд байсан бөгөөд түүнчлэн эмнэлгийн яаралтай тусламжийн өрөө, тасаг нэгжээр нийт 419326 хүнийг эрэмблэн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгжид ажиллаж байгаа эмч, мэргэжилтний 10 гаруй хувь нь яаралтай тусламжийн сургалтанд хамрагдсан байна.


Эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд өвчтөн, үйлчлүүлэгчдийг эмнэлэг хооронд явуулж чирэгдүүлж байдаг хүнд суртлын тогтолцоог халахын тулд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дэргэд яаралтай тусламжийн тасаг, нэгжийг шинэчлэн зохион байгуулж, тэдгээрийн ажиллах үлгэрчилсэн журмыг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн ор, монитор, зохиомол амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн аппаратаар тоноглогдсон түрдэг дамнуурга, зөөврийн эхо аппарат хангалт муу, зөөврийн рентген аппарат огт байхгүй, хэрэглэгдэж байгаа аппарат, багаж тоног төхөөрөмжийн бүрэн ажиллагаатай нь цөөхөн зэрэг<sup>2</sup> нь үйлчлүүлэгчид үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээний шаардлагыг хангахгүй байна.

**Хоёр. Яаралтай тусламжийн тулгамдсан асуудлууд**

**2.1 Яаралтай тусламж (ЯТ) - ийн тасаг, нэгжийн бүтэц, зохион байгуулалт**

- Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцооны хууль эрх зүйн орчин боловсронгуй бус;
- Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт яаралтай тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн орон тоогоор ажиллахгүй байгаа;
- Яаралтай тусламжийн тасаг, нэгжийн ажиллах үлгэрчилсэн зааврыг баталсан боловч ихэнх эмнэлгийн хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, холбоо мэдээллийн хэрэгслийн санхүүжилт нь бүрэн шийдвэрлэгдээгүй;
- Ихэнх эмнэлэг, төвүүдэд яаралтай тусламжийн тасаг, нэгжийг бие даасан хэлбэрээр зохион байгуулаагүй ажиллах журам боловсруулан мөрдөх үйл явц удаашралтай;
- ЯТ-ийн тасаг, нэгжийн байнгын бэлэн байдал, нөөц хангалтгүй
- Эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгж болон эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийн хоорондын уялдаа холбоо байхгүй;
- ЯТ-ийн тасаг, нэгж нь бүтэц, зохион байгуулалтын зураглалыг ил байрлуулаагүй, иж бүрэн тохижуулах засвар үйлчилгээ хийгдээгүй;
- ЯТ-ын тасгийн статистик мэдээллийн тогтолцоо хангалтгүй;
- Яаралтай тусламж, үйлчилгээний зарим чухал үзүүлэлтүүд тухайлбал яаралтай тусламжийн тасагт хандаж тусламж авсан үйлчлүүлэгчдийн тоо, эрэмблэн ангилалт, хийгдсэн шинжилгээ, оношилгооны байдлыг улсын хэмжээнд тооцон гаргах боломжгүй байна.

<sup>2</sup> Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний үйл ажиллагааны үнэлгээний тайлан, ЭМХТ, УБ хот, 2013



- 2.2. Яаралтай тусламжийн чанар, аюулгүй байдал
  - Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй;
  - Эмнэлгийн яаралтай тусламжийн стандарт, эмнэлзүйн удирдамж хангалтгүй, хэрэгжилт сул;
  - Эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн бэлэн байдал бүрэн хангагдаагүй Эмнэлгийн яаралтай тусламжид мэдээллийн технологийг нэвтрүүлэх үйл явц удаашралтай;
  - ЯТ-ийн тасгийн техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам хангалтгүй;
  - Эмнэлэг, төвүүдийн яаралтай тусламжийн тасагт мөрдөгдөх хяналтын хуудас хэрэглэгдээгүй;
  - Судалгаа шинжилгээний ажил хомс.
- 2.3. Хүний нөөцийн хангамж, тогтвор суурьшил, цалин, нийгмийн баталгаа
  - Яаралтай тусламжийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын тогтолцоо сул, олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр боловсрогдоогүй;
  - Яаралтай тусламжийн мэргэшсэн эмч, сувилагч бэлтгэгдээгүй;
  - Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар хангалтгүй;
  - Яаралтай тусламжийн эмч, мэргэжилтнүүд нь ажлын хүнд нөхцөлд ажилладаг, ажлын байрны дарамт, ачаалал ихтэй, хөдөлмөрийн норм, норматив боловсрогдоогүй;
  - Яаралтай тусламжийн эмч, мэргэжилтнүүдийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй, цалин, урамшууллын механизм оновчтой бус.
- 2.4 Санхүүжилтийн байдал
  - Эмнэлгийн яаралтай тусламжийн санхүүжилтийн механизм оновчтой бус;
  - Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний үр ашиг, өртөг зардлыг тооцоолоход бэрхшээлтэй.

**Гурав. Стратегийн зорилго, зорилт хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1. Стратегийн зорилго нь эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох, яаралтай тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, чадавхийг сайжруулахад оршино.

3.2. Стратегийн зорилт:

Нэгдүгээр зорилт: Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох;

Хоёрдугаар зорилт: Эмнэлгийн байгууллагуудын яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх;

Гуравдугаар зорилт: Эмнэлгийн яаралтай тусламжинд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх;

**Дөрөв. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүлээгдэж буй үр дүн**

- 4.1 Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
  - 4.1.1 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний тогтолцооны хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

- 4.1.2 Яаралтай тусламжийн үндэсний (лавлагаа) төв байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;
- 4.1.3 Эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгжийг стандартын дагуу шинэчлэн зохион байгуулах;
- 4.1.4 Хүн амд үзүүлэх эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор түргэн тусламжийн нэгжийг нэгдсэн эмнэлгийн түшиглэн зохион байгуулах ажлыг үе шаттай шийдвэрлэх;
- 4.1.5 Яаралтай тусламж, үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, дүгнэлт гарган санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх;
- 4.1.6 Эмнэлгийн яаралтай тусламжийн чадавхийг сайжруулах зорилгоор яаралтай тусламжийн сургалт, аргазүйн төвийн чадавхийг сайжруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах;
- 4.1.7 Эмнэлгийн яаралтай тусламжтай холбоотой дүрэм, журам, стандарт, эмнэлзүйн удирдамж батлуулж, мөрдүүлэх

**Хүрэх үр дүн:** Хүн амд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт боловсронгуй болж үндэсний хэмжээний нэгдсэн зохицуулалттай болно.

**4.2. Эмнэлгийн байгууллагуудын яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

- 4.2.1 Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их, дээд сургууль, коллежийн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн багц цагийг нэмэгдүүлэх;
- 4.2.2 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сувилагчийг мэргэшүүлэх, тэдгээрийг төрөлжсөн мэргэжлээр бусад улс оронд сургах;
- 4.2.3 Яаралтай тусламжийн резидентийн сургалтын чиглэл, индексийг батлуулах;
- 4.2.4 Яаралтай тусламжийн салбарт 2 жилийн эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй эмч нараас үндсэн мэргэжлийн эмч бэлтгэх;
- 4.2.5 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэшсэн ажилтны хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэн тогтоож, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- 4.2.6 Эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр ажлын байран дээр нь дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;
- 4.2.7 Эмнэлгийн яаралтай тусламжид хэрэглэгдэх нэн шаардлагатай зориулалтын авиомашин, эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, гамшиг болон онцгой байдлын үед хэрэглэх нөөцийг бүрдүүлэх;
- 4.2.8 Өрх, сумын эмч, ажилтнуудын яаралтай тусламжийн талаарх мэдлэг, ур чадварыг үе шаттайгаар тогтмол сайжруулах
- 4.2.9 Нислэгийн үеийн яаралтай тусламжийг бий болгох;
- 4.2.10 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор яаралтай тусламжийн зарим үйлчилгээг иргэний эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх;



- 4.2.11 Эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан олон улсын болон гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах;
  - 4.2.12 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг боловсруулан мөрдүүлэх;
  - 4.2.13 Иргэдийн анхны тусламжийн мэдлэгийг сайжруулах сургалт, сурталчилгааг мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх.
- Хүрэх үр дүн:** Эмнэлэг, төвүүдийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи нэмэгдэж тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

**4.3. Эмнэлгийн яаралтай тусламжинд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

- 4.3.1 Яаралтай тусламжинд зайн анагаахын технологийг ашиглах
- 4.3.2 Яаралтай тусламжийн орчин үеийн оношилгоо, эмчилгээний менежментийг нэвтрүүлэх боломжийг судлах, туршлага солилцох;
- 4.3.3 Яаралтай тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ болон үр ашиг, өртөг зардлын судалгаа хийж, дүгнэлт гаргах;
- 4.3.4 Яаралтай тусламжийн шуурхай байдлыг хангах зорилгоор орчин үеийн харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжөөр хангах;
- 4.3.5 Яаралтай тусламж, үйлчилгээний статистикийн нэн чухал үзүүлэлт бүхий мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- 4.3.6 Яаралтай тусламж, үйлчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх, мэргэжлийн зөвлөл, холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;
- 4.3.7 Яаралтай тусламжийн чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах;
- 4.3.8 Болзошгүй гамшиг, онцгой байдал, шинэ болон шинээр сэргэж байгаа халдварын дэгдэлтийн үеийн яаралтай тусламжийн хэрэгцээ, нөөц, бэлэн байдалд судалгаа хийж дүгнэлт, зөвлөмж гаргах;

**Хүрэх үр дүн:** Яаралтай тусламжийн мэдээллийн сантай болж баримт, нотолгоонд тулгуурласан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг болсон байна.

**Тав. Стратегийн хэрэгжилтийн зохион байгуулалт**

Стратегийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх асуудлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн мэргэжлийн салбар зөвлөл, яаралтай болон түргэн тусламжийн чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

Орон нутгийн түвшинд стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах асуудлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад мэргэжлийн байгууллагатай бүх шатны Засаг дарга хамтран гүйцэтгэнэ.

### **Зургаа. Санхүүжилт**

Улсын нэгдсэн төсөв болон олон улсын зээл тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамтран шийдвэрлэх замаар уг стратегийг хэрэгжүүлнэ.

### **Долоо. Стратегийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

“Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл” Үндэсний стратегийн хэрэгжилтийн үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны харъяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь “Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл” Үндэсний стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25, 01 дүгээр сарын 25-ны дотор Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, яаралтай болон түргэн тусламжийн чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагад тус тус ирүүлж байна.

**Найм. “Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл” стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2014-2019 он)**



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа							Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага	Шалгуур үзүүлэлт/ Санхүүжилт
		2014	2015	2016	2017	2018	2019				
<b>Зорилт 1: Эмнэлгийн яаралтай тусламжийн тогтолцоог боловсронгуй болгох</b> <b>Үр дүн: Хүн амд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт боловсронгуй болж үндэсний хэмжээний нэгдсэн бодлого зохицуулалттай болно.</b>											
1.1	Эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	x	x						ЭМЯ, БТГ ЭМЯ, БХЗГ, ЭТХ	ЭМХТ	Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт
1.2	Яаралтай тусламжийн үндэсний төв байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх			x	x				ЭМЯ, БХЗГ	ЭМХТ	Тушаал, шийдвэр
1.3	Эмнэлгийн яаралтай болон мэс заслын тусламжаар ДЭМБ-ын хамтын ажиллагааны төвийг Монгол улсад байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх	x	x						ЭМЯ, БХЗГ ҮНТЭ	ДЭМБ ЭМШУИС	Тушаал, шийдвэр
1.4	Эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгжийн бүтэц, орон тоо, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх		x						АЭМГ НЭМГ, ЭМЯ	ЭМЯ, БХЗГ, ТЗУГ, СЭЗХ, ЭТХ, ОЭТХ	Төсвийн төсөл
1.5	Хүн амд үзүүлэх эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор түргэн тусламжийн нэгжийг нэгдсэн эмнэлгийг түшиглэн зохион байгуулах ажлыг үе шаттай судлан шийдвэрлэх	x	x	x					ЭМЯ, БХЗГ ЭМЯ, СЭЗХ	ЭМХТ НЭМГ	Тушаал, шийдвэр

1.6	Эмнэлэг, төвийн яаралтай тусламжийн тусламжийн тасаг, нэгжийг үе шаттайгаар шинэчлэн зохион байгуулах	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
1.7	Эмнэлгийн яаралтай тусламжийн загвар тасгийг байгуулах	x	x																																																																																																																																																		
1.8	Эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх			x																																																																																																																																																	

**Зорилт 2:** Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх.  
Хурэх үр дүн: Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын чадавхи нэмэгдэж тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

2.1	Анагаах ухааны болон сувилгахуйн сургуулийн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн багц цагийг нэмэгдүүлэх		X	X								ЭМЯ-ТЗУГ, БШУЯ	ЭМШУИС ЭМХТ	Багц цагийн тоо
2.2	Яаралтай тусламжийн резидентийн сургалтын чиглэл, индексийг батлуулах	X	X									ЭМЯ-ТЗУГ, БШУЯ	ЭМХТ ЭМШУИС	Батлагдсан индекс
2.3	Яаралтай тусламжийн үндсэн мэргэжил олгох сургалт /резидентур/ зохион байгуулах		X	X	X	X	X	X	X			ЭМЯ, ТЗУГ, лавлагаа төвүүд	ОУБ-ууд ЭМБ-ууд	ЯТ-ийн үндсэн мэргэжлийн эмчийн тоо
2.4	Төгсөлтийн дараах мэс засал, эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, дотор зэрэг резидентурын сургалтын хөтөлбөрийн яаралтай тусламжийн цагийг нэмэгдүүлэх		X	X	X	X	X	X				ЭМЯ-ТЗУГ, БШУЯ	ЭМШУИС ЭМХТ	Сургалтын багц цаг
2.5	Яаралтай тусламжийн мэргэжилтнүүдийн үндэсний зөвлөгөөн зохион байгуулах		X		X			X				ЭМЯ-БХЭГ	Холбогдох МСЗ ЭМХТ	Тайлан
2.6	Яаралтай тусламжийн чиглэлээр бусад мэргэжлийн их эмчийг мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах		X	X	X	X	X	X				ЭМЯ, ТЗУГ, ХНХХ, ЭМХТ	Холбогдох МСЗ, мэргэжлийн нийгэмлэг ТББ	Мэргэжил дээшлүүлсэн эмчийн тоо
2.7	Яаралтай сувилгахуйн дээшлүүлэх байгуулах	тусламжийн мэргэжил зохион	X	X	X	X	X	X				ЭМХТ	Төгсөлтийн дараахи сургалтын байгууллага ТББ	Мэргэжил дээшлүүлсэн сувилгахуйн тоо



2.8	Эмнэлгийн яаралтай тусламжийн эмч, сувилагчийг жишиг болгох бусад улс оронд сургах									ЭМЯ-ТЗУГ, БШУЯ	ЭМХТ ОУБ	Сургагдсан хүний тоо
2.9	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн нормыг тогтоох									ЭМЯ	ЗГХА-ЭМГ	Тушаал, шийдвэр
2.10	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд зарцуулж байгаа санхүүжилтийн байдлыг тооцох									ЭМЯ	ЭМХТ	ЭМС-ын үндэсний тооцоо
2.11	Эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан олон улсын болон гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах									ЭМЯ	ЭМХТ ОУБ	Төслийн тоо
2.12	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх									ЭМХТ	НЭМГ НТТТ	Чанарын үнэлгээний дүгнэлт
2.13	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулах									ЭМЯ	ЭМХТ НЭМГ ЭМБ-ууд	Боловсрогдсон шалгуур үзүүлэлт
2.14	"Яаралтай тусламжийн тасаг, нэгж - эмнэлгийн толь" аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулах									ЭМЯ-ЭТХ	ЭМХТ ЭМДсан	Аяны тайлан
2.15	Яаралтай тусламжийн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, лавлагаат тусламж, зөвлөгөө өгөх									ЭМЯ-БХЗГ, ЭТХ	ЭМХТ ЭМБ-ууд	Зөвлөгөөний тоо
2.16	Сум дундын эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах									ЭМЯ-БХЗГ, ЭТХ	ЭМБ-ууд	Тушаал, шийдвэр



3.6	Яаралтай тусламжийн чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах		X	X	X	X	X	X	ЭМЯ, БТГ, БХЗГ	ЭМХТ НЭМИГ ТББ, аж ахуй нэгж	Батлагдсан гэрээ
3.7	Яаралтай тусламжид хэрэглэгдэх нэн шаардлагатай ЭМ, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах		X	X	X	X	X	X	ЭМЯ, БХЗГ, ОЭТХ, СЭЗХ, ЭЭХ Х	ЭМХТ НЭМИГ АЭМИГ ОУБ	Хангалтын тоо
3.8	Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний үр ашиг, өртөг зардлыг тооцох	X							ЭМЯ, БХЗГ, БТГ	ЭМХТ ЭМШУИС	Судалгааны тайлан
3.9	Яаралтай тусламжийн чиглэлээр хийгдэх судалгааны ажлын захиалгыг батлуулж хэрэгжүүлэх		X	X	X				ЭМЯ-БТГ БХЗГ	ЭМХТ ЭМШУИС	Судалгааны ажлын захиалгын тоо
3.10	Болзошгүй гамшиг, онцгой байдал, шинэ болон шинээр сэргэж байгаа халдварын дэгдэлтийн үеийн яаралтай тусламжийн хэрэгцээ, нөөц, бэлэн байдалд судалгаа хийж дүгнэлт, зөвлөмж гаргах		X	X					ЭМЯ-БХЗГ, ХШУДАГ	ЭМХТ ОБЕГ НЭМИГ МУЗН Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Үнэлгээний тайлан, зөвлөмж

Стратегийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

**Ёс. Шалгуур үзүүлэлт**

№	Үзүүлэлт	2012 оны суурь түвшин	2016 онд хүрэх түвшин	2019 онд хүрэх түвшин	Мэдээний эх үүсвэр
1	Шинэчлэн зохион байгуулагдсан ЯТ-ийн тасаг, нэгжийн тоо	-	10	20	ЭМЯ, ЭМХТ
2	Яаралтай тусламжийн чиглэлээр гадаад орнуудад туршлага судлах, сургалтад хамрагдсан хүний тоо	-	6	12	ЭМЯ, мэргэжлийн салбар зөвлөл, ЭМХТ-ийн мэдээ
3	Яаралтай тусламжийн чиглэлээр гадаад оронд бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	2	4	8	ЭМЯ, бусад яамдын мэдээлэл
4	Яаралтай тусламжийн мэргэжлийн эмчийн тоо /мэргэжлийн индекстэй/	0	30	50	ЭМХТ-ийн мэдээ
5	Яаралтай тусламжийн мэргэжил дээшлүүлсэн их эмчийн тоо /3 сарын сургалт/	0	40	80	ЭМХТ-ийн мэдээ
6	Яаралтай тусламжийн мэргэжил дээшлүүлсэн сувилалчийн тоо /3 сарын сургалт/	5	40	80	ЭМХТ-ийн мэдээ
7	Анагаах ухааны боловсрол олгох сургалтын хөтөлбөрт тусгагдсан эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн цаг /багц цагаар/	1 багц цаг	3 багц цаг	6 багц цаг	ЭМШУИС-ийн Сургалтын албаны мэдээлэл
8	Сувиллахуйн сургалтын хөтөлбөрт тусгагдсан эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн цаг /багц цагаар/	-	1 багц цаг	2 багц цаг	ЭМШУИС-ийн Сургалтын албаны мэдээлэл
9	Яаралтай тусламж, үйлчилгээний стандартын тоо	1	3	6	ЭМХТ-ийн мэдээ
10	Яаралтай тусламж, үйлчилгээний удирдамж	0	3	6	ЭМХТ-ийн мэдээ
11	Төлөмөдийн нэвтрүүлсэн эмнэлгийн тоо	21	28	35	ЭМХТ-ийн мэдээ
12	Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлдэг нэгдсэн эмнэлгийн тоо	21	24	27	ЭМХТ-ийн мэдээ